



ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ
ДЭЛХИЙН ЖИШИГ МОНГОЛ ҮЙЛДВЭР

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД БАЙРЛАХ “ХАР ТУГАЛГАТ -
ХҮЧЛИЙН БАТАРЕЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ
ТЕХНОЛОГИОР БОЛОВСРУУЛЖ, БАРИЛГЫН МАТЕРИАЛ
ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСӨЛ”**

**2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: 0000025 /
/РЕГИСТРИЙН ДУГААР: 6352901/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

/А.ЭНХБАТ/

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

/Л.ШИНЭЦЭЦЭГ/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
“ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

“ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

/Ө.ОДОНСҮРЭН/

/Л. ДУЛАМСҮРЭН/



2023 ОН

АГУУЛГА

НЭГ. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3-8
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	9-13
ДӨРӨВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	13
ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14
ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14-15
ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	15
НАЙМ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	15-16
НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	16
АРАВ. 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН	17
ДҮГНЭЛТ.....	18

НЭГ. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТОВЧ

ТАНИЛЦУУЛГА

Монгол улсад агаарын бохирдлын дараа орох хүний эрүүл мэнд болон байгаль орчинд аюултай хор нөлөө үзүүлж байгаагийн нэг нь хар тугалгын бохирдол юм.

Өдөр ирэх бүр өсөн нэмэгдэж буй автомашины өсөлт, үүнээс гарах хаягдал аккумулятор нь хог хаягдлын стандарт шаардлагыг хангахгүйгээр Монгол улсын нутаг дэвсгэрт тархан хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хор нөлөө учруулсаар байна.

Иймээс бид энэхүү аюултай хар тугалгын бохирдлыг бууруулахад өөрийн хувь нэмрийг оруулах үндсэн зорилготойгоор сүүлийн 5-н жилийн судалгаа, шинжилгээнд тулгуурлан “Хар тугалгат- хүчлийн батареийг байгаль орчинд ээлтэй технологиор боловсруулж, барилгын материал үйлдвэрлэх” төслийг хэрэгжүүлэхээр Налайх дүүргийн 3-р хороонд, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэн байгуулсан болно.

Хаягдал аккумулятор буюу хар тугалгын батареийг боловсруулахтай холбоотойгоор Монгол улсад мөрдөгдөж буй хууль, журмын дагуу үйл ажиллагаагаа эхэлж үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулан батлуулсан, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан батлуулсан ба холбогдох тусгай зөвшөөрлүүдийг авсан.

Цаашид Бид Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Газрын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зэрэг Монгол улсад мөрдөгдөж буй бусад холбогдох дүрэм, журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд онцгой анхаарч ажиллах болно.

Манай компани Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан бөгөөд тус төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын биелэлтийн тайланг үүгээр хүргэж байна.

2023 онд бид өөрийн үйлдвэрийг ашиглалтанд оруулахтай холбоотой бэлтгэл ажлуудыг хийсэн бөгөөд үйлдвэрийн барилгыг харахан дуусгаагүй, үйлдвэрийн тоног төхөөрмжийг оруулж ирэн угсарч, суурьлуулах болон зарим дэд бүтцийн ажлуудыг хийсэн болно.

Цаашид 2024 оны 2-р улиралд багтаан бэлтгэл ажил бүрэн дуусч үйлдвэрийг ашиглалтанд оруулж, улсын комисст хүлээлгэн өгөх ба албан ёсоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэх юм. Дулааны улирал эхэлмэгц гадна тохижилт цэцэрлэгжүүлэлт, Ногоон байгууламж болон түүнтэй холбоотой нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэх болно.

ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн тодорхойлолт

Төслийн нэр:	Хар тугалгат - хүчлийн батареийг байгаль орчинд ээлтэй технологиор боловсруулж, барилгын материал үйлдвэрлэх төсөл
Төслийн байршил:	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэн байгуулна.
Төсөл хэрэгжүүлэгч:	“Электрокем Монгол” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011756132, Регистрийн дугаар: 6352901
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Ханну төв -500 тоот Утас:99114175, 77229999

2.2. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт

Тус компани нь жилд 5000 тн хаягдал батареий дахин боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай ажиллах ба жилд 2900 тн хар тугалган бүтээгдэхүүн, 500-600 тн гөлтгөнө үйлдвэрлэнэ. Эхний жилд 2500 тн хаягдал батареийг дахин боловсруулж 1450 тн хар тугалган бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх бол үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт аажмаар нэмэгдэж 5 дахь жилд 4500 тн хаягдал батареий боловсруулж, 2600 тн хар тугалган бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Үйлдвэрлэсэн гөлтгөнийг 100 хувь цементийн дотоодын үйлдвэрүүдэд, хар тугалган бүтээгдэхүүний 20 орчим хувийг дотоодын зах зээлд, үлдэгдэл 80 орчим хувийг БНХАУ болон БНСУ-ын зах зээлд борлуулахаар төлөвлөсөн.

Мөн үйлдвэрийн хүчин чадлаа бүрэн ашиглаж эхэлсэн нөхцөлд 600 орчим тн угааж цэвэрлэсэн хуванцар дайвар бүтээгдэхүүн, 700 орчим тн саармагжуулсан шааран дайвар бүтээгдэхүүн гарган авна.

Хаягдал батареийг дахин боловсруулах үйлдвэрийн онцлог, холбогдох стандартын дагуу тавигдаж байгаа шаардлагууд болон хаягдал батареийг тээвэрлэх болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэргийг харгалзан үзэж үйлдвэрийг “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийг түшиглэн байгуулсан.

Үйлдвэрийн хэрэгцээнд 4 га газар шаардлагатай бөгөөд үүний 1.2 га талбайд үйлдвэрийн үндсэн байр, хаягдал батареийг түр хадгалах агуулах, үйлдвэрээс гарах хорт утааг цэвэршүүлэх систем, хар тугалган бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех, шаарыг саармагжуулах цех, эцсийн бүтээгдэхүүнийг хадгалах агуулах зэргийг барьж байгуулах бол үлдсэн хэсэгт үйлдвэрийн захиргаа оффисын барилга болон ажилчдын амрах байрыг төлөвлөсөн.

Хаягдал батареийг дахин боловсруулах үйлдвэрт нийтдээ 34 ажилчид ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд эдгээрт үйлдвэрийн менежер, ээлжийн ахлагч, техникийн ажилчид болон туслах ажилчид, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн

цехийн ажилчид, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын ажилтан зэрэг орон тоо багтаж байна. Ажлын цаг нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу 1 ээлжид 8 цаг, жилд 250 хоног ажиллана.

2.3. Үйлдвэрийн товч танилцуулга

“Электрокем Монгол” ХХК-ийн хар тугалгат - хүхрийн хүчлийн батарейны талаар сүүлийн 3 жилд хийсэн судалгаа, үйл ажиллагааны ололтуудыг хослуулж батарейг дахин боловсруулж гарсан түүхий эд материалаар барилгын материал үйлдвэрлэх бизнес төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.



Зураг 1. Үйлдвэрийн барилгын харагдах байдал

Энэхүү төслийн хүрээнд дараах барилгын материалуудыг үйлдвэрлэнэ. Үүнд:

1. Батарейны хүхрийн хүчлийн уусмалыг цэвэршүүлэн саармагжуулж, цемент үйлдвэрлэлийн гол түүхий эд болох гипс буюу гөлтгөнө үйлдвэрлэх, улмаар гипсэн хавтан үйлдвэрлэх
2. Хар тугалган хавтан, хуулга, ялтас (дээвэр, дээврийн ам дарагч, усны хаялга, парпетны малгай, бетон суурийг хөрснөөс тусгаарлагч)
3. Хар тугалган тоосго (рентген туяанаас тусгаарлагч хана)
4. Замын хавтан зэрэг болно.

2.3.1. Гөлтгөнийн үйлдвэрлэл

Тус үйлдвэр хар тугалгат - хүхрийн хүчлийн батарейг дахин боловсруулах үйл ажиллагааны явцад гарах хаягдал бүтээгдэхүүн болох 15-30%-ийн концентраци бүхий хүхрийн хүчлийн уусмалыг цэвэршүүлэн улмаар шохойтой урвалд оруулж боловсруулах замаар гөлтгөнө буюу гипсийг гаргаж авах юм.

Гөлтгөнө буюу гипс нь $\text{CaSO}_4 \cdot 2\text{H}_2\text{O}$ томъёогоор илэрхийлэгдэх сульфатуудын төрөл бөгөөд цайвар цагаан өнгөтэй байдаг. Гөлтгөнийг дараах байдлаар өргөн хэрэглэдэг. Үүнд:

- ✓ Хөдөө аж ахуйд хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх бордоо хэлбэрээр
- ✓ Барилгын хуурай хана хэмээн нэрлэгдэг төрөл бүрийн гипсэн хавтан, гипсэн блок
- ✓ Барьцалдах чадварыг тохируулах зорилгоор цементийн үйлдвэрлэлд нэмэлт

орцоор

- ✓ Металлургийн салбарт хүдрийг баяжуулахад
- ✓ Өндөр буюу 90-95 хувийн агуулгатай гипсийг эмнэлгийн салбарт хэрэглэдэг.

Гөлтгөнийг гаргаж авах боломжит 3 арга байдаг бөгөөд эдгээрээс дараах 2 арга нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой тул дэлхий нийтэд өргөн хэрэглэгдэж байна. Үүнд:


- ✓ Байгалийн гөлтгөнө чулууг боловсруулж гөлтгөнө гаргаж авах.
- ✓ Шохойноос гөлтгөнө үйлдвэрлэх зэрэг болно.

Байгалийн гөлтгөнө чулууг ашиглан гөлтгөнийг гарган авахдаа чулууг бутлах, шигших, тээрэмдэх, нунтаглах гэх мэт дамжлага аргаар боловсруулан цэвэрлэж улмаар кальцижуулах процесс буюу 1200-1800 хэмийн өндөр температурт хүчилтөрөгчийн орчинд халаах технологийг ашигладаг.

Харин шохойн чулуунаас гөлтгөнө гарган авах нөгөө арга нь CaCO_3 томьёогоор илэрхийлэгдэх шохойг H_2SO_4 томьёогоор илэрхийлэгдэх хүхрийн хүчлийн уусмалтай тодорхой температур болон даралттай орчинд урвалд оруулж гаргаж авдаг.

Шохойг хүхрийн хүчлийн уусмалтай урвалд оруулан гөлтгөнө гарган авах аргын хувьд үйлдвэрлэлийн явцад шаардагдах цахилгааны зардал нь нөгөө аргыг бодвол арай өндөр боловч голлох түүхий эд болох шохойн чулууны олдоц элбэг болоод үнэ харьцангуй хямд, нөгөө талаар түүхий эд болох хүхрийн хүчил нь тус төслийн хувьд батареийг дахин боловсруулах явцад гарсан хаягдал бага байх тул зардал багатай, эцсийн бүтээгдэхүүн болох гөлтгөнийн агууламж өндөр буюу 92 хувьд хүргэх боломжтой.

Үйлдвэрлэлээс гарган авсан гөлтгөнийг эхний ээлжид дотоодын цементийн үйлдвэрүүдэд нийлүүлэх, улмаар дараагийн шатанд холбогдох судалгааг хийсний үндсэн дээр барилгын хуурай хана гэгдэх гипсэн хавтан, гипсэн блок үйлдвэрлэх зорилготой.



Зураг 2. Гөлтгөнө үйлдвэрлэл

Гөлтгөнийг цементийн барьцалдах хугацааг нь тохируулах/бууруулах зорилгоор 5-8 хувийн орцтойгоор цементийн найрлагад ашигладаг. Өнөөгийн байдлаар манай орны жилд хэрэглэх цементийн хэмжээг 2 сая тн хэмээн тооцоолсон байдаг бол сүүлийн 5 жилийн дотор Хөтлийн цемент шохойн үйлдвэр технологийн шинэчлэл хийж хүчин чадлаа нэмэгдүүлсэн, МАК, Монполимет болон Мөнхийн баян тал гэх мэт 3 үйлдвэр тус бүр жилд 1 сая тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтайгаар ашиглалтад орсон зэргээс үүдэн дотоодын цемент үйлдвэрлэлийн хүчин чадал жилд 4.0 сая тн давжээ.

2.3.2. Хар тугалган хавтан, хуулга, тоосго үйлдвэрлэл

Төслийн хүрээнд хаягдал батареийг дахин боловсруулж гарган авсан түүхий эд материалаар үйлдвэрлэж болох гол бүтээгдэхүүн нь хар тугалган хавтан, хуулга болон хар тугалган тоосго юм.


Хар тугалган хавтан болон хуулгыг барилга байшин дээвэрлэх, дээврийн ам дарах зориулалтаар ашиглах, усны хаялга хийх, парпетний малгай хийх зэрэг одоо

манай улсын барилгын салбарт гөлмөн төмрөөр хийж байгаа бүхий л дээвэр болон усны хаялгатай холбоотой ажлыг гүйцэтгэж болохын зэрэгцээ бетон суурийг хөрснөөс тусгаарлахад ашиглаж болно.

Хар тугалга нь зэврэлтэд ордоггүй, ус нэвтрүүлэхгүй учраас бусад ямар ч материалаас илүү удаан эдэлгээтэй, бас уян хатан, ямар нэгэн бодистой урвалд ордоггүй, өнгө үзэмжээ алддаггүй, насжилт удаан зэрэг онцгой давуу талтай учир барууны өндөр хөгжилтэй орнуудад эрт дээр үеэс эхлэн өнөөг хүртэл энэ зориулалтаар өргөн ашиглаж байна.

Хар тугалганы бас нэгэн онцгой шинж нь рентген туяаг нэвтрүүлдэггүй болно. Түүний энэхүү шинж чанарыг ашиглан дэлхий ертөнц эмнэлгийн төрөл бүрийн шинжилгээний явцад гарах рентген туяаны хор нөлөөнөөс эмнэлгийн эмч ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн хамгаалах зорилгоор рентген өрөө, түүний ойр орчмыг хар тугалган тоосгон хана, хар тугалган хавтан зэргээр хийж хамгаалдаг.

2018 оны статистик тоон мэдээгээр манай улс тус онд нийт 134000 ам.долларын үнэ бүхий хар тугалган хуулга, ялтсыг импортлон авч дээрх зориулалтаар ашигласан байна.



Зураг 3. Хар тугалган хавтан, хуулга, тоосго үйлдвэрлэл

2.3.3. Замын хавтан үйлдвэрлэл

Тус үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллах үед жилд 5000 тн хаягдал батареи дахин боловсруулахад үйлдвэрийн үйл ажиллагаанаас 700 орчим тн шаар хаягдана. Энэхүү шаар нь 5-7 хувийн хар тугалга агуулсан байх тул олон улсын ангиллаараа аюултай хог хаягдалд тооцогддог. Иймд энэхүү шаарыг аюултай хог хаягдлын адилаар тооцож холбогдох устгах арга хэмжээг авах шаардлагатай. Харин шаарыг булшлах тусгай ландфил манай улсад өнөөгийн байдлаар байхгүй байна. Иймд энэхүү шаарыг Олон улсын Хар тугалганы Холбооны зөвлөх Брайн Вилсоны удирдамж болгосон дагуу цааш боловсруулж замын хавтан үйлдвэрийн орцонд хэрэглэх шийдлийг технологи нийлүүлэгч компанитайгаа тохиролцон ажиллаж байна. Үйлдвэрээс хаягдах шаарны химийн найрлагыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Үйлдвэрээс хаягдах шаарны химийн найрлага

№	Химийн элемент	Хуурай үед эзлэх хувийн жин
1.	Натри - Na (Na ₂ O, Na ₂ SO ₄)	43.20
2.	Төмөр - Fe (FeS, Fe ₂ O ₃)	21.10
3.	Хар тугалга - Pb (PbS, PbO)	5.43
4.	Цахиур - Si (SiO ₂)	5.71
5.	Цальци - Ca (CaO)	3.42
6.	Нүүрстөрөгч - C	9.40
7.	Хүхэр - S (Total)	9.54
8.	Бусад - Cr, Cu, Zn, Ti	1.1

Гадна ашиглах замын хавтангийн 20 хүртэл хувьд нь хаягдал шаарыг оруулж түүнийг үйлдвэрлэх боломжтой. Хаягдал шаарыг замын хавтангийн орцонд ашиглахад 2 төрлийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:

Нэгдүгээрт, Хаягдал шаарт байх хар тугалга гэх мэт хүнд металлын байгаль орчинд хаягдах эрсдэлийг арилгах шаардлагатай. Үүний тулд $Ba(OH)_2$ томьёогоор илэрхийлэгдэх Барийн гидроксидыг мөн хавтангийн орцонд нэмэх юм. Барийн гидроксидыг ашигласнаар Барийн Сульфат буюу $BaSO_4$ үүсгэх бөгөөд ингэснээр шааранд байх хар тугалганы тоосонцор агаарт дэгдэхгүй байх боломж бүрдэж байгаль орчныг бохирдуулах нөхцөлийг хаах юм.

Хоёрдугаарт, Хавтангийн орцонд шаар ашиглах нь түүний даацыг бууруулах тул хавтангийн даац буюу барьцалдах чадварыг нэмэгдүүлэхийн тулд гөлтгөнө буюу гипсийг ашиглах юм.

Дээрх байдлаар ашигласан батареийг дахин боловсруулах үйл ажиллагаанаас бий болох шаарыг саармагжуулж, улмаар замын хавтан үйлдвэрлэдэг жижиг үйлдвэрүүдэд хүчлийг боловсруулж гарган авсан гөлтгөнийн хамт нийлүүлж хамтран ажиллахаар төлөвлөсөн.


2.4. Хар тугалгат хүчлийн батареийг дахин боловсруулах технологи

Энэтхэг улсын Гравита хэмээх үйлдвэрийн батареи дахин боловсруулах үйлдвэрийг судалж, энэхүү технологийг нэвтрүүлэхээр төлөвлөсөн. Тус компанийн үйлдвэрлэсэн техник технологи нь Олон улсын хар тугалганы холбооноос “Магадлан итгэмжлэл” авах шалгуурыг хангах түвшинд үйлдвэрлэгддэг давуу талтай учир энэхүү үйлдвэрийг сонгосон.

Энэхүү технологи нь 5 дамжлагын үйл ажиллагаатай бөгөөд батареийг автоматаар буталж, хүчил, хар тугалга, тусгаарлагч эбонет болон хуванцар гэсэн хэсгүүдэд ялгахгаас гадна хэрэглэсэн усаа дахин цэвэршүүлж үйлдвэрлэлдээ дахин ашигладаг давуу талтай. Мөн түүнчлэн эбонет болон хуванцарыг цэвэрлэж хуванцар дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх боломжтой болохын зэрэгцээ хар тугалгыг хайлуулах болон цэвэршүүлэх дамжлагаар 99.98% цэвэр хар тугалган гулдмай үйлдвэрлэж улмаар энэхүү гулдмайг цааш хэвэнд цутган төрөл бүрийн зузаантай хавтан, хуулга болон тоосго үйлдвэрлэдэг. Энэхүү технологийн давуу тал нь электродын хар тугалган шаваасыг десульфатацид оруулах аргыг хэрэглэх бөгөөд ингэснээр хайлах температурыг багасгаж хайлуулах процессын үед ялгарах утаан дахь хорт бодисыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах нөхцөлийг бүрүүлдэг онцлогтой.

2.5. Ашиглалтаас гарсан хар тугалгат хүчлийн батареийг дахин боловсруулах үе шат

Хаягдал батареийг түр хадгалах агуулахад хүлээн авч хадгалснаар дахин боловсруулах үе шат эхэлнэ. Энэ хэсэгт батареийг дахин боловсруулах үйл ажиллагааг нарийвчлан тайлбарлахаас гадна энэхүү үйл ажиллагааг байгаль орчин болоод хүний биед хор хөнөөлгүй гүйцэтгэхэд анхаарах чухал шаардлагуудыг тайлбарлах болно.



Зураг 4. Ашиглалтаас гарсан батерейг дахин боловсруулах үйл ажиллагааны схем

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Агаарын чанар

1. Барилга барих талбай, түүний орчимд үүсэх тоосжилтыг бууруулахын тулд барилгын ажил явагдаж байгааг анхааруулсан тэмдэг болон замын хөдөлгөөний дүрэмд заасан хурдны хязгаарыг мөрдүүлэн, тэмдэгжүүлэлт хийсэн.



Зураг 5. Хурдны хязгаар заасан тэмдэг байршуулсан байдал

2. Барилгын талбай доторх автомашины ба явган хүний явах зам тогтсон нэг замаар зорчуулах, машины зогсоол гаргаж 2500 мкв талбайг хайрган хучилттай болгож засан тохижуулсан.



Зураг 6. Хайрган хучилттай зам талбай тохижуулсан байдал

3. Барилгын үйл ажиллагаанд ашиглагдах барилгын материалыг, салхины нөлөөгөөр тоосжилт үүсэхээргүй газар байршуулж, бүтээсэн бөгөөд тээвэрлэх явцад битүү контейнерээр тээвэрлэсэн болно.



Зураг 7. Барилгын угсрлаланд ашигдах материалыг бүтээсэн байдал



Зураг 8. Барилгын угсрлаланд ашигдах материалыг тээвэрлэж буй байдал

4. Мөн бид барилгын ажил ид явагдаж байх үед буюу 2023 оны 05-р сард Агаарын чанарын шинжилгээг өгсөн болно. Уг шинжилгээний дүнг Хавсралт№1-т харуулав.

3.2. Газрын гадарга, хэвлий

1. Барилгын суурь, ус, дулааны шугам хоолой тавих газрыг ухахын өмнө геодезийн хэмжилт хийх, нарийвчилсан төлөвлөгөө гаргах, ухах суурилуулах ажлыг хурдан шуурхай гүйцэтгэх, буцаан булж, тэгшлилсэн.



Зураг 9. Суурь ухахын өмнө геодезийн хэмжилт хийж төлөвлөсөн байдал

2. Төслийн барилга байгууламжийн зураг төсөлд тусгагдсан явган зам, тээврийн хэрэгслийн зогсоол зэрэг газруудыг технологийн дагуу хайргаар зассан хучилт хийх ажлыг 2023 онд хараахан дуусгаж амжаагүй бөгөөд 2024 оны 5 сард дулааны улиралд бүрэн хийж дуусгах болно.
3. Газар шорооны ажилд өртөж эвдэрсэн талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт хийсэн.



Зураг 10. Газар шорооны ажил хийсний дараах харагдах байдал

4. Газар ухах, барилгын талбайн хэсэгт шөнө оройд харагдахаар аюулгүйн бүс татах, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, барилгын улаан шугам татан ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэсэн. Улаан шугам тавьсан акт Хавсралт№2-т харуулав.

3.3. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг

1. Төслийг хэрэгжүүлэх явцад төслийн талбай болон түүний ойр орчимд олон салаа зам гаргахаас сэргийлэн нэг маршрут таргасан.



Зураг 11. Нэг маршруттай замын харагдах байдал

2. Төслийн талбайн эзэмшил газрын хил зааг дотор явган зам, талбай, автомашины зогсоолын талбай зэргийг байгалийн чулуун, хайрга ашиглан зам талбай бэлдсэн ба 2023 онд гадна зам талбай тохижилтын ажил бүрэн дуусаагүй болно.



Зураг 12 Хайрган хучилттай зам талбай тохижуулсан байдал

3. Эхний ээлжинд үйлдвэрийн барилгын ойр орчмыг нөхөн сэргээж, ногоон байгууламж барихаар төлөвлөж байна. Үүнд 2500м² талбайг нөхөн сэргээж ногоон байгууламж хийх, 500 орчим мод, бут, суулгац тарихаар төлөвлөж байна. Цаашид үйлдвэрийн үйл ажиллагаа өргөжөхийн хирээр энэхүү үйл ажиллагааг тогтмолжуулах болно.
4. 2024 оны хавар гадна зам талбай тохижилтын ажил бүрэн дууссаны дараа 5 сард ногоон багууламж, зүлэгжүүлэлтийн ажлыг хийх болно.
5. Барилгажилт, гадна тохижилтын ажил бүрэн дууссаны дараа орчны тохижилт ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийн ажлыг стандартын дагуу гүйцэтгэх ба мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах болно.

3.4. Усан орчин

1. Үйлдвэрийн ахуйн хэрэгцээний усыг Налайх дүүргийн УСУГ-тай гэрээ байгуулан зөөврийн ус авч ашигласан. Ус ашиглах гэрээг Хавсралт№3-т харуулав.
2. Технологийн усны хэрэглээг гүний худагийн эх үүсвэрээр ханганахаар “Эрдэнэдриллинг” ХХК-тай худаг гаргуулах гэрээ байгуулан холбогдох зөвшөөрлийг авч үйлдвэрийн технологийн хэрэгцээнд зориулан 150м гүнтэй 1 гүний худаг гаргасан ба мөн 1 цэгт усны түвшин, чанарын хяналт хийх зориулалт бүхий гүний усны хяналтын цооног байгуулсан.



Зураг 13 Хайрган хучилттай зам талбай тохижуулсан байдал

3. 2024 онд дахин нэг цэгт усны түвшин, чанарын хяналт хийх зориулалт бүхий гүний усны хяналтын цооног байгуулна.
4. Цаашид технологийн усыг бүрэн цэвэршүүлэн дахин ашиглах учир хаягдал гаргахгүй.
5. Гүний худаг, хяналтын цооног гаргах зөвшөөрлийг Нийслэлийн Байгаль орчны газраас авсан. Зөвшөөрлийн бичгийг Хавсралт№4-т харуулав
6. Шинээр гаргасан худгийг паспортыг Байгаль орчин, аялал жуулчлалын газраар баталгаажуулах, бүртгэлжүүлсэн. Паспортыг Хавсралт№5-д хавсаргав
7. Гүний худгаас дээж авч шинжилгээнд өгсөн. Шинжилгээний бичгийг Хавсралт№6-д харуулав
8. Хяналтын усны цооногт усны шинжилгээг хийлгэсэн. Хавсралт№7-д харуулав
9. Гүний худаг, хяналтын цооногт Мэргэжлийн эрх бүхий байгууллагаар тоолуур тавиулж баталгаажуулахаар хүсэлт өгсөн.
10. Цаашид технологийн усны хэрэглээ 70тн байх бөгөөд нэг удаагийн дүргэлт хийсний дараа тасралтгүй цэвэршүүлэн дахин ашиглана. Ингэхдээ өдөрт дунджаар 2тн орчин нөхөн дүүргэлт хийгдэнэ. Технологийн усны жилийн нийт хэрэглээг 300 орчим тонн байхаар тооцоолж байна. Технологийн шугамд ашиглагдаж байгаа усыг бүрэн дахин ашиглах учир хаягдал гарахгүй. Ахуйн хэрэглээний усний жилийн нийт хэрэглээг 600 тонн байхаар тооцоолж байна. Ахуйн хэрэглээний хаягдал усыг цуглуулан тээвэрлэж, УСАГ-ийн төвлөрсөн усан татуургад нийлүүлнэ.
11. Барилгын ажлын үед сордог бетонон доторлогоотой, түр ариун цэврийн байгууламж хийсэн.

ДӨРӨВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бид орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт, зүлэгжүүлэлт, Ногоон байгууламжийн ажлыг төлөвлөгөөний дагуу 2024 онын 5-р сард багтаан хийхээр төлөвлсөн ба арчилгааг зун болон намырн улиралд хийх болно.

ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус төслийн талбай нь суурьшлын бүс нутаг бөгөөд одоогоор түүх, соёлын өв илрээгүй.

Төслийн барилгын ажлын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Ахуйн болон барилгын хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, ариутгах, тээвэрлэх графикийг гаргаж, гэрээ байгуулан ахуйн болон барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт хаясан. Хог хаягдалын гэрээг Хавсралт№8-д хавсаргав.
2. Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт нийлүүлсэн.
3. Барилгын ажлын үед хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулан технологийн дагуу доторлосон зориулалтын сав байрлуулж, ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж үржихээс урьдчилан сэргийлж ариутгал хийж, хогийг хуримтлуулахгүйгээр зориулалтын цэгт тогтмол зайлуулсан.



Зураг14 Байрлуулсан хогийн савны харагдах байдал

4. Ахуйн хог хаягдлыг ариун цэврийн бүсээс 60 м-ээс багагүй зайд, салхины зонхилох чиглэлийн дагуу, төслийн барилга байгууламжийн доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд цуглуулсан.
5. Манай үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал байхгүй бөгөөд цаашид ашигласан химийн бодисын сав баглаа боодол зэргийг аюултай хог хаягдах хадгалах саванд хадгалж, аюултай хог хаягдал устгах зөвшөөрөгдсөн компанитай гэрээ байгуулан ажиллах болно.

ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

1. Үйлдвэрийн хашаан дотор, хог хаягдлын цэгийн орчим, тариалангийн талбайд 1 удаа хөрсний ерөнхий физик химийн шинж чанар /рН, ялзмагийн агууламж, ялзмагт давхаргын зузаан, механик бүтэц, нийт азот, нийт фосфор, хүнд металлын агууламж/-ыг тодорхойлсон. Шинжилгээний хариуг Хавсралт№9-д харуулав.
2. Унд ахуйд хэрэглэж буй зөөврийн усанд ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоог хэмжсэн. Шинжилгээний хариуг Хавсралт№9-д харуулав.
3. Унд ахуйд хэрэглэж буй зөөврийн усыг Налайх дүүргийн ус сувгийн удирдах газартай гэрээ байгуулж зөөврийн ус хэрэглсэн.
4. Цаашид үйлдвэр ашиглалтанд ормогц хөтөлбөрийн дагуу хөрс, ус агаарын шинжилгээг улирал бүр авч хүнд метал болон эмгэг төрүүлэгчийг тодорхойлуулж байх болно.

НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан 2024 оны 1-р улиралд багтаан Эрх бүхий Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, Барилга, хот байгуулалт, геодези зурагзүйн газраар дүгнэлт гаргуулах болно.
2. Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан. Төлөвлөгөөний хуулбарыг Хавсралт№10-д хавсаргав.
3. Үйлдвэр ашиглалтанд орох хүртэл түр харуулын байранд галын аюулаас урьдчилан сэргийлэх, унтраах багаж, галын хор байрлуулж, заавар зөвлөмжийг байрлуулсан.

7. Мөн Налайх дүүргийн эрүүл мэндийн үйлдвэрийн ажилчид болон үйлчилгээний ажилтнууд эрүүл мэндийн үзлэгт улиралд нэг удаа хамруулхаар гэрээ байгуулсан бөгөөд үйлдвэрийн ажил эхлэхийн өмнө буюу 2024 оны нэгдүгээр улиралд багтаан шинжилгээнд хамруулах болно. Гэрээний хуулбарыг хавсралт№12-д харуулав.
8. Төслийн хүрээнд ашиглагдаж буй техник, технологи, машин механизмын техник хэрэгслээс дуу шуугиан гарах бөгөөд орчинд үзүүлэх нөлөөлөл нь хязгаарлагдмал боловч тухайн орчинд ажиллагсдад сөрөг нөлөөтэй тул хамгаалах хэрэгслээр хангаж ажилласан.

НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд БОМТ-нд тусгагдсан арга хэмжээ биелэлт, гүйцэтгэлийн тайланг боловсруулж явуулсан.
2. Налайх дүүргийн засаг даргад БОМТ-нд тусгагдсан арга хэмжээ биелэлт, гүйцэтгэлийн тайланг хүргүүлсэн.

АРАВ. 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН

Улаанбаатар хотын Налайх дүүрэг, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийг түшиглэн байгуулах “Хар тугалгат - хүчлийн батареийг байгаль орчинд ээлтэй технологиор боловсруулж, барилгын материал үйлдвэрлэх төсөл”-ийн 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулсан нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт зардал /мян.төн/
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	13,570.00
2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	мян.төг	46,340.00
3.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	мян.төг	6,400.00
4.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	-
5.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр – 2023 он	мян.төг	1,200.0
6.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	мян.төг	
7.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө – 2023 он	мян.төг	-
БҮГД ДҮН			67,510.00

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 67,510 мян.төг /Жаран долоон сая таван зуун арван мянган төгрөг/ зарцуулав.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Налайх дүүргийн 3-р хороонд байрлах Хар тугалгат - хүчлийн батареийг байгаль орчинд ээлтэй технологиор боловсруулж, барилгын материал үйлдвэрлэх төслийн хүрээнд 2023 онд батлуулсан “2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний биелэлтийн тайланг байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулан хүргүүллээ.

Бид сүүлийн 5 жилийн судалгаа шинжилгээнд тулгуурлан Монгол улсад тулгараад байгаа хар тугалгын бохирдол болон түүнээс үүдэн гарах хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөг бууруулах үндсэн зорилготойгоор энэхүү төслийг хэрэгжүүлхэр шийдсэн.

Тиймээс манай компанийн үндсэн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх явдал юм. Энэ ч утгаараа бид байгаль орчинд халгүй технологийг сонгон авч олон улсын хар тугалгын холбооноос зөвлөсний дагуу Энэтхэг улсад тэргүүлэгч Gravita компаниас тоног төхөөрөмжөө нийүүлэн авсан болно.

Мөн цаашид бид өөрийн үйл ажиллагаандаа чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001, Байгаль орчны менежментийн систем ISO 14001 болон ХАБЭА-ын ISO 45001 стандартуудыг нэвртүүлж ажиллахаар төлөвлөж байна.

